



АУДИТЫН КОД: САГ-2017/29/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261740 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддрож
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Аудитын санал дүгнэлтийн талаар	9
2.9.2	Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар	9
2.9.3	Түүвэрт хамрагдсан байгууллагуудын талаар	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	11
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	12
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	12
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	14
3.1	Хариуцлага тооцох талаар	15
3.2	Дотоод хяналтын талаар	16
3.3	Мөнгөн хөрөнгийн талаар	17
3.4	Үндсэн хөрөнгийн талаар	18
3.5	Авлага, өр төлбөрийн талаар	19
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	20
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	20
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	21
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	26

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 767
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн:

- "Мон-Атом" ХХК нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийн 96.3 сая төгрөгийн авлага, байгууллагуудад төлөх 109.0 мянган ам.доллар буюу 216.1 сая төгрөгийн өр төлбөрийг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0425SAG33.Docx

Мөн 201.0 мянган ам.долларын буюу 500.4 сая төгрөгийн зээлийн гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагыг толилуулж тодруулаагүй, хамтарсан компанид оруулсан 51.0 мянган ам.доллар буюу 127.0 сая төгрөгийн болон 755.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтаар бүртгээгүй, эзэмшлийн хувь хэмжээ бодитой эсэхийг нотлох хангалттай бөгөөд зохистой нотолгоо байхгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, баримтын бүрдэлгүй 77.5 сая төгрөгийн зөрчилтэй.

- “Шивээ овоо” ХК: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж, сонгон шалгаруулалтгүйгээр, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй 13,097.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг гэрээ байгуулахгүйгээр шууд худалдан авсан.
- “Эрдэнэс таван толгой” ХК: Санхүүгийн тайланд ашиглалтгүй, 5,328.9 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө болон удаан хугацаанд хууль хяналтын байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн, үйлдвэрлэлд ашиглагдахгүй 4,836.3 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.
БНХАУ-ын “Чалко” компанитай байгуулсан урьдчилгааны гэрээнд заасны дагуу “Худалдан авах зорилтот хэрэглэгчдэд нүүрс худалдах дэд бүтэц, ложистикийг БНХАУ-д бий болгох”-д зориулж 2,000.0 мянган ам.доллар буюу 2,642.3 сая төгрөгийг тус компанид төлж, урьдчилж гарсан зардалд бүртгэсэн бөгөөд хүлээн авагч тал уг төвийг байгуулсан эсэхийг тодорхойлоогүй, гэрээг дүгнээгүй зэрэг зөрчлүүд байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 05-наас 2017 оны 4 дүгээр сарын 21-ний хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн

ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01/766 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилготой ажиллаж байна. Үүнд:

- Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Түлш (эрчим хүчний нүүрснээс бусад)-ний хангамж, нөөцийн талаарх бодлого боловсруулах, газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрийн суурийг тавьж хөгжүүлэх, улмаар дотоодын боловсруулах үйлдвэрийг байгуулах;
- Байгалийн хий болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн (нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) талаарх судалгаа, хайгуул, олборлолтыг дэмжин хөгжүүлж, хийжүүлэх, шингэрүүлэх замаар гүн боловсруулалт хийх, ТЭЗҮ боловсруулах, боловсруулах үйлдвэр байгуулах;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
- Уул уурхайн салбарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, байгаль орчинд халгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаандаа Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай, Ашигт малтмалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журмуудыг мөрдөн ажиллаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-A-5/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус яамны 2016 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 3,640.2 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-B1/

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 8 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-B-3/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын “Дотоод аудитын төлөвлөгөө батлах” тухай 2016 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар 2016 онд дотоод аудитын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг батлуулсан байна. Уг тушаалаар 2016 онд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас дараах чиглэлээр дотоод аудит хийхээр төлөвлөж гүйцэтгэжээ. Үүнд:

- “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2014-2015 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2016 оны 5 дугаар сард дотоод аудит хийжээ. Аудитаар Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын бүтэц, орон тоо, цалингийн санг батлах тухай 2013 оны 345 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан орон тоог 3-аар хэтрүүлсэн зөрчил илэрч, зөвлөмж хүргүүлсэн байна.

- “Геологийн судалгааны төв” ТӨҮГ-ын 2014-2015 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2016 оны 6 дугаар сард хийсэн дотоод аудитаар нийт 9 зөрчил илрүүлж, холбогдох арга хэмжээ авах талаар зөвлөмж хүргүүлжээ.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь тайлант жилд 7 ажил хийхээр төлөвлөсөн боловч дээрх 2 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна. Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны аппаратын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний байдлаарх санхүүгийн баримтад 18 зөрчил илрүүлж холбогдох арга хэмжээ авах талаар зөвлөмж өгчээ.

Дээрх байдлаас үзвэл, батлагдсан төлөвлөгөөний дагуу дотоод аудитыг бүрэн гүйцэд хийж байх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэгддэг ТӨҮГ, ТӨААТҮГ болон төсвийн байгууллагуудад дотоод хяналт хийх талаар төлөвлөгөөнд тусгаж, дотоод хяналтыг сайжруулан ажиллах шаардлагатай байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйлээр хуваарилах зэрэгт хяналт тавин ажилласан байна.

Төсвийн орлого:

2016 оны Төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын төвлөрүүлэх орлогыг 167,544.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс:

- Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Газрын тосны газар /хуучин нэрээр/-т 69,222.1 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 69,917.0 сая төгрөг, Ашигт малтмалын газар /хуучин нэрээр/-т 20,688.4 сая төгрөгөөр баталснаас 28,579.3 сая төгрөг төвлөрүүлжээ. Нийт 8,585.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
- Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор дээрх 2 байгууллагыг нэгтгэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрыг шинэчлэн байгуулсан.
Тус байгууллага газрын тосны орлогоор 54,561.0 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 65,383.8 сая төгрөгийг төвлөрүүлж 19.8 хувиар давуулан биелүүлсэн, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, улсын төсвөөр хийсэн хайгуулын нөхөн төлбөрийн орлогоор 15,781.9 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 19,454.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нийт орлогын төлөвлөгөөг 23.3 хувь буюу 14,495.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Батлагдсан зардлын төсөв /төсвийн тодотголоор/ 1,797.8 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,651.1 сая төгрөгийг зарцуулсан буюу төсвийн гүйцэтгэл 91.8 хувьтай байна.

Төсвийн зарлага:

2016 оны Төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн урсгал зардлыг 8,520.9 сая, хөрөнгийн зардлыг 9,341.1 сая, нийт төсвийг 17,862.0 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр хөрөнгийн зардлыг төлөвлөсөн хэмжээнд буюу 9,341.1 сая, урсгал зардалд 7,079.3 сая, нийт 16,420.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1,441.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 91.9 хувьтай байгаа нь төсвийн орлогын эх үүсвэрийн дутагдалтай байдлаас шалтгаалан төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарласантай холбоотойгоор Сангийн яамнаас 1,441.6 сая төгрөгийг дутуу санхүүжүүлжээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагддаг “Шивээ овоо” ХК нь Шилэн дансны тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх тухай заалтыг бүрэн хангаж ажиллаагүй байна. Тус байгууллага шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-нд ямар ч мэдээлэл оруулаагүй байна.

“Геологийн судалгааны төв” ТӨҮГ 2016 онд шилэн дансны цахим хуудсаар тайлагнаж байршуулбал зохих 133 мэдээллийн 119 мэдээллийг оруулж 89.5 хувийн хэрэгжилттэй байна.

“Мон-Атом” ХХК нь 2016 оны зорилтот түвшин, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, санхүүгийн тайлан (хагас, бүтэн жилээр), санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тушаал шийдвэр зэрэг мэдээллийг шилэн дансны хуудсанд оруулаагүй байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд /www.shilendans.gov.mn/ харьяа төсөвт байгууллагууд болон дээр дурдсанаас бусад ТӨҮГ-ууд мэдээллээ байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад ТЕЗ-ийн мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 18 байгууллага нэгтгэсэн тайланд хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан нийт 18 салбар, нэгжийн 6 байгууллагад “Зөрчилгүй”, 2 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгч, 5 байгууллагын хаалтын балансад завсрын аудит, 3 байгууллага аудитын түүвэрт, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №1/

Д/д	Байгууллага	Хаалтын тайлан	Зөрчилгүй	Хязгаар- лалттай	Татгалзсан	Түүвэрт хамрагдсан	Аудит хийгдээгүй
1	Ашигт малтмалын газар	+					
2	Газрын тосны газар	+					
3	Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл	+					
4	Уул уурхайн аврах алба	+					
5	Геологийн мэдээллийн төв	+					
6	УУЯ-ны аппарат					+	
7	Геологийн байгууллага					+	
8	УУЯ-ны хөрөнгө оруулалт					+	
9	Геологийн судалгааны төв ТӨҮГ		+				
10	Геологийн төв лаборатори ТӨҮГ		+				
11	“Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ		+				
12	“Эрдэнэс оюу толгой” ХХК		+				
13	“Эрдэнэс Монгол” ХХК		+				
14	Ашигт малтмал, газрын тосны газар		+				
15	“Мон-Атом” ХХК				+		
16	“Шивээ овоо” ХК			+			
17	“Эрдэнэс таван толгой” ХК			+			
18	Тогтвортой бичил уурхай төсөл						+
	ТЕЗ Нийт	5	6	2	1	3	1

2.9.1 Аудитын санал дүгнэлтийн талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэгдсэн “Мон-Атом” ХХК, “Шивээ овоо” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Татгалзсан”, “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “... санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”, 28.2-т “Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”, 28.2.1-д “аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд” гэж заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад зөвлөмж өгөх.

2.9.2 Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан “зөрчилгүй” санал дүгнэлт авсан нэр бүхий 6 байгууллагад 6,966.3 сая төгрөгийн 28 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,144.7 сая төгрөгийн 6 албан шаардлага, 4,819.2 сая төгрөгийн 21 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.3 Түүвэрт хамрагдсан байгууллагуудын талаар

Түүвэрт 3 байгууллага хамрагдсанаас нийт 2,084.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 3.2 сая төгрөгийн 1 акт, 8.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2,073.3 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн болно.

1. Яамны аппарат бэлэг, дурсгалын зүйл болон хүндэтгэлийн зоог барих, албан томилолтын төсөв, шатахуун зарцуулалтын норм, засвар үйлчилгээний зардлыг хэтрүүлэн нийт 15.0 сая төгрөгийг илүү зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 16, 2 дугаар хавсралтын 4, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасныг дагаж мөрдөх тухай зөвлөмж өгөх.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 125 дугаар тогтоолоор 583.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны аппаратад шилжиж ирсэн байна. Дээрх үндсэн хөрөнгийн газар эзэмших эрхийн гэрчилгээ нь Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /хуучин нэрээр/-ны нэр дээр бүртгэлтэй байна. Уул уурхайн яам /хуучин нэрээр/-наас “Тоёо инженеринг” корпорацитай 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын гэрээ”-ний дагуу 1,450.0 сая төгрөгийн ажил хийгдэж дууссан боловч санхүүгийн тайланд дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх үндсэн хөрөнгө болон дуусаагүй барилга байгууламжийн талаар зохих шийдвэр гаргаж, холбогдох арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх.

3. Нэр бүхий 2 байгууллагатай холбоотой 25.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөр тус бүр дээр тооцоо нийлж баталгаажуулж байх зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитаар анхаарал татахуйц, цаашид нарийвчлан шалгах шаардлагатай дараах асуудлууд илэрсэн болно. Үүнд:

“Шивээ овоо” ХК:

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 338 дугаар тогтоолоор тус компанийн “НИК” ХХК, “Сод Монгол групп” ХХК-д төлөх нийт 2.9 тэрбум төгрөгийн шатахууны өрийг “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн татварын илүү төлөлтөөс суутган тооцох замаар шийдвэрлэхийг Сангийн сайд, Гааль татварын ерөнхий газрын дарга нарт зөвшөөрсөн ч уг тогтоол хэрэгжээгүй байна.
- “Шивээ овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан 2016 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд толгой компанийн удирдлагын зардлыг нийт үйл ажиллагааны зардлын 3 хувиар тооцож оруулснаар 2016 онд “Эрдэнэс Монгол” ХХК-д төлөхөөр 1,405.1 сая төгрөгийн менежментийн зардал бүртгэгдсэн байна.

“Мон-Атом” ХХК:

- “Мон-Атом” ХХК-ийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийг зохицуулах эрх зүйн зохицуулалт дутмаг, тодорхой бус байгаагаас тус компанийн үндсэн үйл ажиллагааны зардлыг гадаад, дотоодын компаниудаас зээл авч нөхөж байна. Иймд тус компани хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орлого, санхүүжилтийн асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.
- Хамтарсан компанид БНЧУ-ын “Ураниум Индастри” ХК-иас хөрөнгө оруулалт хийх зорилгоор “Мон-Атом” ХХК руу шилжүүлсэн 2,000.0 мянган ам.долларыг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй, мөн “Мон-Атом” ХХК-иас хамтарсан компанийн дүрмийн санд оруулах анхны хөрөнгө оруулалт 51.0 мянган ам.долларыг “Ураниум Индастри” ХК-иас зээлийн гэрээгээр авахаар тохиролцсон боловч гүйцэтгэлийг нь баталгаажуулж, данс бүртгэлд тусгаагүй, “Төв Азийн Уран” ХХК-ийн төрийн төлөөллийн эзэмшлийн хувь, хөрөнгийн дүн тодорхойгүй байгаа зэрэг асуудлуудтай холбоотойгоор өр төлбөр нэмж үүсэх эрсдэл өндөр байна. Эдгээрээс шалтгаалж зээлийн үндсэн төлбөр, түүний хүү, торгуулийн төлбөр нэмэгдэж, компани цаашилбал Монгол Улсын Засгийн газрын өр төлбөр нэмэгдэхэд хүрч болзошгүй байна.
- “Мон-Чех Ураниум” хамтарсан компанид Монголын талаас орд газар буюу лицензээр оруулсан хөрөнгө оруулалтыг хэрхэн бүртгэсэн, 2013 оноос 15 хувийг эзэмших болсон “Гурван сайхан” ХХК болон гэрээ хэлэлцээрийн шатанд байгаа хамтарсан компанийн хөрөнгө оруулалт хэрхэн яаж бүртгэгдсэн, дээрх компаниуд ямар үйл ажиллагаа эрхэлж байгаа, хэрхэн хяналтыг хэрэгжүүлж байгааг тодруулж шалгах шаардлагатай байна. Аудитын явцад “Мон-Атом” ХХК нь хамтарсан компанид Засгийн газрын төлөөлөх эрхийг хэрхэн хэрэгжүүлж тайлагнасныг үнэлээгүй болно. Хамтарсан болон хөрөнгө оруулалт хийсэн компаниудын үйл ажиллагаа, хөрөнгийн үр өгөөжид гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай байна.
- “Эрдэнэс Оюу Толгой” ХХК байгуулагдсан цагаасаа хойш нийт 5,719.7 сая төгрөгийн зээлийн өртэй байгаа, цаашид орлогын эх үүсвэр тодорхойгүй, үйл ажиллагааг үргэлжлүүлэх, эс үргэлжлүүлэх талаарх шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох дээд шатны байгууллагын шийдвэрийг харгалзан үзэх шаардлага гарч байна.
- Уул уурхайн яамны хөрөнгө оруулалтын дансанд дуусаагүй үйлдвэрлэлд бүртгэлтэй байсан 3,593.0 сая төгрөгийн автоматжуулалтын тоног төхөөрөмж, програм хангамжийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1135 тоот албан бичгээр Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Дээрх балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүй байна.
- Швейцарийн Холбооны Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн санхүүгийн тайлан аудит хийгдэлгүй нэгтгэгдсэн нь Швейцарийн Холбооны Агентлагаас буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй бүх төсөл, хөтөлбөрүүдийн зарцуулалтад санхүүжүүлэгчийн зүгээс жил бүр олон улсын аудит хийгддэг шалтгаантай байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна. Үүнд:

- Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж буй Сангийн яамны “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй,
- Төрийн сангийн газраас ирүүлсэн ТЕЗ болон Сангийн яам хоорондын тооцоо нийлсэн баримтад хөрөнгийн санхүүжилт, зардлын гүйлгээг тусгаагүй,
- Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

- Засгийн газрын 2016 оны 192 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын эзэмшлийн 12 айлын орон сууцыг хувьчлахаар шийдвэр гарсан ба орон сууцны хувьчлалтай холбоотой материалыг Сангийн яамнаас хянан үзэж хувьчлахыг зөвшөөрсөн байна. Дээрх хувьчлалтай холбоотой ТӨХ-ны шийдвэр гараагүй байна.
- “Эрдэнэс Монгол” ХХК нь 2014 онд “Гашуун сухайт Авто зам” ХХК /“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХХК, “Таван толгой” ХК/-тай байгуулсан “Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг гүйцэтгэх” гэрээний дагуу тус замаар тээвэрлэсэн нүүрс болон уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тоо бүртгэл хөтлөлт, авто замын тариф, хураамжийн орлого цуглуулалт, авто замын ашиглалт, арчлалт, урсгал болон их засварын ажилд гарсан зардлыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж байна. Тайлант онд өртгийн дансанд 8,856.7 сая төгрөгийг хуримтлуулан бүртгэснээс зам засвар арчлалт, урсгал болон их засвартай холбоотой зардал нь 5,135.8 сая төгрөг, үлдэх 3,720.9 сая төгрөгийн өртөг нь “Гашуун сухайт авто зам” ХХК-ийн борлуулалт, удирдлага болон зам ашиглалтын зардал байна.
- Тайлант онд “Эрдэнэс Монгол” ХХК-д Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд гарсан зардлыг үйл ажиллагааны зардлаас тусад нь бүртгэсэн байна. Аудитад ирүүлсэн мэдээллээр энэ төслөөс гадна 10 гаруй төсөл хөтөлбөр байна. Дээрх төслүүд цаашид хэрэгжих эсэх, эсвэл зөвхөн судалгааны шатанд байгаа эсэх, тайлант үед гаргасан зардал болон төслийн үр дүнг үнэлээгүй байгааг шалгах шаардлагатай байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 644,126.40 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 564,760.3 сая төгрөгийн 19 залруулга, 5.6 сая төгрөгийн зөрчилд 2 акт, 15,252.7 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 64,107.8 сая төгрөгийн зөрчилд 50 зөвлөмж өгсөн болно.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг биелүүлж, 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2017 оны 04/781 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 364,021.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 3,640.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын явцад илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэл болж байна. Үүнд:

- “Мон-Атом” ХХК: Нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийн 96.3 сая төгрөгийн авлага, байгууллагад төлөх 109.0 мянган ам доллар буюу 216.1 сая төгрөгийн өр төлбөрийг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан, нийт 201.0 мянган ам.долларын зээлийн гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагыг толилуулж тодруулаагүй, хамтарсан компанид оруулсан 51.0 мянган ам.доллар, 755.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтаар бүртгээгүй, эзэмшлийн хувь хэмжээ бодитой эсэхийг нотлох хангалттай бөгөөд зохистой нотолгоо байхгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, баримтын бүрдэлгүй 77.5 сая төгрөгийн зөрчилтэй,
- “Шивээ овоо” ХК: Холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, гэрээ байгуулахгүйгээр батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй, 13,097.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан,
- “Эрдэнэс таван толгой” ХК: Компанийн санхүүгийн тайланд ашиглалтгүй, тодорхой шийдвэргүй 5,328.9 төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө болон удаан хугацаанд хууль хяналтын байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн, үйлдвэрлэлд ашиглагдахгүй 4,836.3 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.
БНХАУ-ын “Чалко” компанитай байгуулсан урьдчилгааны гэрээнд заасны дагуу “худалдан авах зорилтот хэрэглэгчдэд нүүрс худалдах дэд бүтэц, ложистикийг БНХАУ-д бий болгох”-д зориулж 2,000.0 мянган ам.долларыг тус компанид төлж, урьдчилж гарсан зардалд бүртгэсэн бөгөөд хүлээн авагч тал уг төвийг байгуулсан эсэхийг тодорхойлоогүй, гэрээг дүгнээгүй байна.

Дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн болон Дотоод аудитын албаны ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 ХАРИУЦЛАГА ТООЦОХ ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэгдсэн “Мон-Атом” ХХК, “Шивээ овоо” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Татгалзсан”, “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн аудитын байгууллагаас санал дүгнэлт өгөх боломжгүй, хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан “зөрчилгүй” санал дүгнэлт авсан нэр бүхий 6 байгууллагад 6,966.3 сая төгрөгийн 28 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,144.7 сая төгрөгийн 6 албан шаардлага, 4,819.2 сая төгрөгийн 21 зөвлөмж өгсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх,

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Яамны аппарат бэлэг, дурсгалын зүйл болон хүндэтгэлийн зоог барих, албан томилолтын төсөв, шатахуун зарцуулалтын норм, засвар үйлчилгээний зардлыг хэтрүүлэн нийт 15.0 сая төгрөгийг илүү зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 16, 2 дугаар хавсралтын 4, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасныг тус тус зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 16, 2 дугаар хавсралтын 4, Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 19 тоот тушаалын 1 дүгээр хавсралтанд заасныг тус тус мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 125 дугаар тогтоолоор 583.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны аппаратад шилжиж ирсэн байна. Уг үндсэн хөрөнгийн газар эзэмших эрхийн гэрчилгээ нь Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /хуучин нэрээр/-ны нэр дээр бүртгэлтэй байна.

Уул уурхайн яам /хуучин нэрээр/-наас “Тоёо инженеринг” корпорацитай 2013 оны 5 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын гэрээ”-ний дагуу 1,450.0 сая төгрөгийн ажил хийгдэж дууссан боловч санхүүгийн тайланд дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Дээрх үндсэн хөрөнгө болон дуусаагүй барилга байгууламжийн талаар зохих шийдвэр гаргаж, холбогдох арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно

3.5 Авлага, өр төлбөрийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №5

ҮАГ-ын ажиглалт

Нэр бүхий 2 байгууллагатай холбоотой 25.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Авлага, өр төлбөр тус бүр дээр тооцоо нийлж баталгаажуулж байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд хөрөнгө мөнгө дутуу бүртгэгдэх, ашиглал шамшигдал үүсэх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөг/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,068,616.8	302,191,884.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	966,760.5	53,593,162.7
33	АВЛАГА	9,754,223.2	63,906,738.4
34	УРЬДЧИЛГАА	37,141,546.7	67,704,406.9
34600	Урьдчилж гарсан зардал	36,931,568.7	56,686,370.9
35	БАРАА МАТЕРИАЛ	2,030,696.1	82,222,826.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	11,589,359.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	34,502,001.9	2,184,550,931.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	757,428.1	1,552,105,749.0
373	Урт хугацаат зээл	757,428.1	1,552,105,749.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,744,573.8	632,445,182.8
392	Биет хөрөнгө	20,775,710.3	112,131,086.0
393	Биет бус хөрөнгө	12,968,863.5	163,943,988.0
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	356,370,108.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	107,570,618.7	2,486,742,816.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,126,376.6	1,293,232,853.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,131,119.6	458,870,103.4
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	120,028.7
413	Өглөг	2,658,808.1	392,322,280.2
414	Урьдчилж орсон орлого	472,311.5	66,427,794.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,995,257.0	834,362,749.6
422	Урт хугацаат зээл	4,995,257.0	834,362,749.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	99,444,242.1	1,193,509,963.0
51	Засгийн газрын хувь оролцоо	99,444,242.1	1,193,509,963.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	35,547,338.7	1,586,117,631.6
5110	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	18,176,902.4	16,670,462.0
51101	Өмч: - төрийн	15,734,849.7	16,469,683.0
51102	- хувийн	-	134,190.0
51103	- хувьцаат	-	1,207,710.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,635,586.6	1,551,635,586.6
512	Хуримтлагдсан үр дүн	62,445,862.2	(394,058,709.9)
51210	Өмнөх үеийн үр дүн	56,287,848.4	(203,665,709.0)
51220	Тайлант үеийн үр дүн	6,158,013.8	(190,393,000.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,451,041.3	1,451,041.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	107,570,618.7	2,486,742,816.0

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	239,186,499.9	360,190,779.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	50,869,864.8	36,810,969.4
110	Орлогын албан татвар	-	2,100.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	2,100.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	50,869,864.8	36,808,868.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	171,436,060.9	312,228,740.0
120	Нийтлэг татварын бус орлого	169,672,760.0	308,961,792.4
122	Тусламжийн орлого	1,763,300.9	3,266,947.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,880,574.2	11,151,069.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	232,160,416.6	364,021,265.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232,160,416.6	360,428,266.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,092,827.6	170,982,742.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,871,767.7	5,268,870.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	482,474.1	480,103.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,263.0	446,763.0
2104	Хангамж, бараа материалын зардал	399,980.4	328,628.5
2105	Нормативт зардал	8,441.5	11,929.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	116,945.3	54,787.3
2107	Томилолт, зочны зардал	511,917.0	434,902.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,604,641.3	161,884,624.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,866,397.3	2,072,134.3
211	ХҮҮ	-	4,189,150.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	216,067,589.0	185,256,373.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,592,998.6

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,026,083.3	(3,830,486.2)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	77,190.6	959,428.8
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	945,260.0	187,521,943.5
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>6,158,013.8</u>	(190,393,000.9)

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ
C01	2015 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	77,213,602.6		77,213,602.6
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	15,406,586.0		15,406,586.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,620,188.6		92,620,188.6
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	666,039.7		666,039.7
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	6,158,013.8		6,158,013.8
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,444,242.1		99,444,242.1
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,444,242.1		99,444,242.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,284,423,888.5		1,284,423,888.5
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,383,868,130.6		1,383,868,130.6
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	34,833.3		34,833.3
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	(190,393,000.9)		(190,393,000.9)
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,193,509,963.0		1,193,509,963.0

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	244,072,964.8	390,039,569.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,360,994.6	36,810,969.4
110	Орлогын албан татвар	2,940,449.4	2,100.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,940,449.4	2,100.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,420,545.2	36,808,868.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,420,545.2	36,808,868.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,491,251.6	341,689,628.4
120	Нийтлэг татварын бус орлого	219,727,950.7	338,422,659.8
122	Тусламжийн орлого	1,763,300.9	3,266,968.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,220,718.6	11,538,972.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	233,439,067.9	323,236,628.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233,439,067.9	323,236,628.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,082,320.4	137,768,643.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,467,995.1	29,646,365.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,186,079.9	7,038,990.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	467,794.8	7,256,651.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,368,919.4	21,098,159.7
2105	Нормативт зардал	420.0	4,056.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	133,119.0	82,335.6
2107	Томилолт, зочны зардал	536,601.2	584,537.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,214,783.3	71,823,903.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	706,607.7	233,642.4
212	ТАТААС	635,707.6	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	217,721,039.9	185,467,985.0

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,633,896.9	66,802,941.7
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	21,577.1	916,645.5
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,157,264.5	15,954,234.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,157,264.5	15,954,234.9
2200	Дотоод эх үүсвэрээр	11,157,264.5	15,954,234.9
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,135,687.5)	(15,037,589.4)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	37,759.3	861,049.9
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(464,031.3)	52,626,402.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,430,791.8	966,760.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	966,760.5	53,593,162.7

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ	
		БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,861,954.6	16,420,369.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,520,854.6	7,079,269.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,830,003.8	5,594,409.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,604,753.9	3,584,111.0
210101	Үндсэн цалин	2,465,411.1	2,487,196.7
210102	Нэмэгдэл	762,115.8	739,500.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	239,294.8	239,294.7
210104	Урамшуулал	82,237.1	82,237.1
210105	Гэрээт ажлын хөлс	55,695.1	35,881.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	396,522.9	394,352.1
210201	Тэтгэврийн даатгал	252,332.9	244,330.7
210202	Тэтгэмжийн даатгал	28,837.9	24,378.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,047.6	37,505.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,209.6	13,127.3
210205	Эрүүл мэндийн даатгал	72,094.9	75,010.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,545.9	227,999.0
210301	Гэрэл, цахилгаан	30,147.6	25,155.5
210302	Түлш, халаалт	101,909.3	93,583.6
210303	Цэвэр, бохир ус	25,889.0	10,727.9
210304	Байрны түрээс	100,600.0	98,532.0
2104	Хангамж, бараа материалын зардал	235,528.9	212,837.2
210401	Бичиг хэрэг	79,206.2	66,197.3
210402	Тээвэр, шатахуун	33,727.6	38,163.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,769.1	69,071.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960.0	360.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,866.0	39,045.0
2105	Нормативт зардал	1,400.0	416.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,400.0	416.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,091.5	25,127.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,504.0	3,920.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400.0	1,252.4
210604	Урсгал засвар	37,187.5	19,954.6
2107	Томилолт, зочны зардал	287,903.5	211,069.9
210702	Дотоод албан томилолт	287,903.5	211,069.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	989,757.2	934,028.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	852,932.8	811,295.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	29,635.3	29,170.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,914.2	7,499.3

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	536.5	536.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	79,228.9	79,212.4
210807	Газрын төлбөр	11,509.5	4,200.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,000.0	2,113.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,500.0	4,468.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,500.0	4,468.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,690,850.8	1,484,860.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,690,850.8	1,484,860.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	231,537.8	159,427.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,296,250.0	1,209,119.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,063.0	96,256.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000.0	20,056.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,341,100.0	9,341,100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	9,341,100.0	9,341,100.0
223001	Бусад хөрөнгө	9,341,100.0	9,341,100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,861,954.6	16,420,369.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,570,704.6	10,211,250.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	10,570,704.6	10,211,250.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,291,250.0	6,209,119.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,291,250.0	5,852,839.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	356,279.5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	260	260
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	209	209
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	50	50
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1